

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/166/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: saranchimeg.ts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	22
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	22
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	22
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХК	Хувьцаат компани
ТӨХК	Төрийн өмчит Хувьцаат компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.04.25 № 01/05
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ү.НАРАНТУНГАЛАГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүн тайлангаас зөрүүтэй, элэгдлээр анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй, төрийн мэдлийн газар эзэмших эрхийн бүртгэл зөрүүтэй, хөрөнгийн зардлаас урсгал зардлыг санхүүжүүлсэн, ОНХС болон бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр ирсэн мал амьтдыг гэрээлсэн гэрээний хэрэгжилт хангалтгүй, хуульд заагаагүй нэмэгдлийг улс төрийн албан хаагчдад олгосон, төлбөрийн шилжүүлсэн дүн цахим баримтын дүнгээс зөрүүтэй зэрэг нийт 339,030.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг

ашигласан байна. ЗДТГ нь 2023 онд төсвийн хөрөнгөөр 153,247.9 мянган төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сан, бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 402,185.6 мянган төгрөгийн хөрөнгийг сайжруулалт болон үндсэн хөрөнгөнд орлого авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл байхгүй байна.

Баяндэлгэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 5 дугаар сарын 06-ний өдрийн ээлжит хуралдаанаар 2023 онд сумын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг болон ажлын төлөвлөгөөг батлуулсан байна. Баяр наадмын талбайг цогцоор нь шинэчлэн барих 187,899.9 мянган төгрөгийн өртөгтэй ажлыг Гарден сити ХХК хийж гүйцэтгэж ашиглалтад оруулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	143,024,493.58	225,419,668.08
33	АВЛАГА	725,013.03	104,060,836.03
33500	Бусад авлага	0	103,335,823.00
33510	Байгууллагаас авах авлага	0	103,335,823.00
35	БАРАА МАТЕРИАЛ	142,299,480.55	121,358,832.05
35400	Хангамжийн материал	119,737,311.55	99,050,163.05
35410	Бичиг хэргийн материал	462,934.00	927,136.00
35420	Аж ахуйн материал	32,977,320.80	37,284,584.30
35440	Түлш, шатах тослох материал	6,368,358.95	1,302,619.95
35450	Барилгын засварын материал	2,073,400.00	1,786,950.00
35460	Хүнсний материал	287,200.00	240,870.00
35470	Бусад хангамжийн материал	77,568,097.80	57,508,002.80
35600	Мал амьтад	22,562,169.00	22,308,669.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,175,522,989.99	1,599,346,620.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,175,522,989.99	1,599,346,620.89
39200	Биет хөрөнгө	1,135,717,131.69	1,514,908,704.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,042,913,935.68	1,367,179,305.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-376,023,550.35	-415,403,293.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	282,755,145.00	282,755,145.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-156,525,254.75	-174,413,123.75
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	234,681,981.62	250,583,177.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,297,664.52	-101,686,275.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,637,810.96	25,905,109.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,508,660.79	-22,494,058.59
39214	Бусад үндсэн хөрөнгө	262,888,529.00	379,412,820.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-75,805,140.16	-76,930,102.50
39300	Биет бус хөрөнгө	39,805,858.30	84,437,916.71
39301	Програм хангамж	3,095,510.00	3,095,510.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,285,651.70	-2,247,593.29
39303	Бусад биет бус хөрөнгө	37,996,000.00	83,590,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,318,547,483.57	1,824,766,288.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,025,220.00	1,573,619.62
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,025,220.00	1,573,619.62
41300	Өглөг	1,025,220.00	1,573,619.62
41360	Бусад өглөг	1,025,220.00	1,573,619.62
41361	Байгууллагад төлөх өглөг	1,025,220.00	1,573,619.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,317,522,263.57	1,823,192,669.35
51	Засгийн газрын хувь оролцоо	1,317,522,263.57	1,823,192,669.35
51100	Засгийн газрын оруулсан капитал	144,833,442.83	190,427,442.83
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	144,833,442.83	190,427,442.83
51200	Хуримтлагдсан үр дүн	746,210,108.29	1,207,441,546.67
51210	Өмнөх үеийн үр дүн	400,508,092.61	747,365,140.89
51220	Тайлант үеийн үр дүн	345,702,015.68	460,076,405.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	426,478,712.45	425,323,679.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,318,547,483.57	1,824,766,288.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	860,982,061.13	1,557,405,009.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	392,682,351.00	374,040,385.00
120	Нийтлэг татварын бус орлого	392,682,351.00	374,040,385.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	101,993,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0	101,993,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн	354,231,361.00	268,191,585.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа	38,450,990.00	3,855,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	468,299,710.13	1,183,364,624.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,616,810.13	359,781,624.63
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт	23,942,693.00	230,746,917.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	50,674,117.13	129,034,707.63
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	393,682,900.00	823,583,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн	393,682,900.00	823,583,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	515,280,045.45	1,088,221,367.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500,038,181.28	1,071,353,181.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,361,766.13	1,029,779,613.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147,163,614.59	368,548,987.77
210101	Үндсэн цалин	124,763,382.71	243,017,033.11
210102	Нэмэгдэл	14,851,718.29	92,696,889.06
210104	Урамшуулал	7,548,513.59	32,835,065.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	19,390,946.99	45,862,635.81
210201	Тэтгэврийн даатгал	13,635,689.56	31,496,348.75
210202	Тэтгэмжийн даатгал	1,466,807.60	3,705,452.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,173,445.55	3,132,506.54
210204	Ажилгүйдлийн даатгал	268,458.03	673,673.99
210205	Эрүүл мэндийн даатгал	2,846,546.25	6,854,653.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,487,704.22	53,359,966.40
210301	Гэрэл, цахилгаан	2,906,284.22	6,233,591.40
210302	Түлш, халаалт	39,581,420.00	47,126,375.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,687,706.80	47,160,016.95
210401	Бичиг хэрэг	2,605,097.00	7,429,478.00
210402	Тээвэр, шатахуун	9,164,010.00	35,011,539.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,918,599.80	3,518,999.95
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	0	1,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,496,000.00	4,960,000.00
210702	Дотоод албан томилолт	4,496,000.00	4,960,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	17,945,303.68	4,750,278.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	16,898,907.68	3,103,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	163,350.00	380,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,046.00	349,068.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	196,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,190,489.85	505,137,728.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,366,172.70	382,335,094.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,824,317.15	122,802,634.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,676,415.15	41,573,568.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,404,900.00	5,492,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,379,600.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	14,026,300.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	999,000.00	5,492,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн	82,271,515.15	36,081,568.12
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,271,515.15	36,081,568.12
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,241,864.17	16,868,186.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,241,864.17	16,868,186.00
221001	Их засвар	15,241,864.17	0
223001	Хаагдсан данс	0	16,868,186.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	345,702,015.68	469,183,641.94
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	9,107,236.16
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	8,807,236.16
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0	300,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-	345,702,015.68	460,076,405.78

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	468,716,310.13	1,179,030,324.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	468,716,310.13	1,179,030,324.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,033,410.13	355,447,324.63
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	23,942,693.00	230,746,917.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	51,090,717.13	124,700,407.63
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	393,682,900.00	823,583,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн	393,682,900.00	823,583,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	428,954,820.13	883,974,319.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,954,820.13	883,974,319.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	327,278,404.98	842,400,751.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,349,317.73	368,717,987.77
210101	Үндсэн цалин	119,339,237.86	244,053,142.31
210102	Нэмэгдэл	16,947,387.98	92,567,899.25
210104	Урамшуулал	14,062,691.89	32,096,946.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	18,586,439.24	45,862,635.81
210201	Тэтгэврийн даатгал	12,714,919.38	31,496,348.75
210202	Тэтгэмжийн даатгал	1,495,872.80	3,705,452.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,196,698.40	3,132,506.54
210204	Ажилгүйдлийн даатгал	274,270.99	673,673.99
210205	Эрүүл мэндийн даатгал	2,904,677.67	6,854,653.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,059,084.22	52,631,566.78
210301	Гэрэл, цахилгаан	2,906,284.22	6,233,591.40
210302	Түлш, халаалт	39,152,800.00	46,397,975.38
2104	Хангамж, бараа материалын зардал	12,323,152.80	20,136,679.95
210401	Бичиг хэрэг	1,404,553.00	2,479,880.00
210402	Тээвэр, шатахуун	9,000,000.00	10,146,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,918,599.80	3,518,999.95
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	0	3,991,800.00
2105	Нормативт зардал	240,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	240,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,499,960.00	2,300,000.00
210604	Урсгал засвар	1,499,960.00	2,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,496,000.00	4,960,000.00
210702	Дотоод албан томилолт	4,496,000.00	4,960,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	23,492,493.99	6,640,278.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	22,446,097.99	4,993,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	163,350.00	442,378.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,046.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	184,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,231,957.00	340,151,603.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,231,957.00	340,151,603.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,676,415.15	41,573,568.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,404,900.00	5,492,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,379,600.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,026,300.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	999,000.00	5,492,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад	82,271,515.15	36,081,568.12
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,271,515.15	36,081,568.12
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	39,761,490.00	295,056,005.20
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	39,761,490.00	295,056,005.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,761,490.00	295,056,005.20
2200	Дотоод эх үүсвэрээр	39,761,490.00	295,056,005.20
223001	Бусад хөрөнгө	23,911,600.00	141,808,089.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,849,890.00	153,247,916.20
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН	-39,761,490.00	-295,056,005.20
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
101	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	144,833,442.83	426,478,712.44	400,508,092.62	971,820,247.89
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	144,833,442.83	426,478,712.45	400,508,092.61	971,820,247.89
9	Тайлант үеийн үр дүн	0	0	345,702,015.68	345,702,015.68
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	144,833,442.83	426,478,712.45	746,210,108.29	1,317,522,263.57
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	144,833,442.83	426,478,712.45	746,210,108.29	1,317,522,263.57
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	1,155,032.60	1,155,032.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	144,833,442.83	426,478,712.45	747,365,140.89	1,318,677,296.17
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-1,155,032.60	0	-1,155,032.60
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	45,594,000.00	0	0	45,594,000.00
19	Тайлант үеийн үр дүн	0	0	460,076,405.78	460,076,405.78
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,427,442.83	425,323,679.85	1,207,441,546.67	1,823,192,669.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	өмнөх он		Тайлант он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	393,266,300.00	329,655,987.98	895,767,600.00	806,309,399.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	354,466,300.00	289,894,497.98	601,897,600.00	512,501,394.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	339,440,000.00	274,869,197.98	596,369,600.00	507,009,394.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,701,900.00	150,349,317.73	419,131,400.00	344,330,506.96
210101	Үндсэн цалин	163,773,500.00	119,339,237.86	300,258,800.00	243,041,418.87
210102	Нэмэгдэл	37,928,400.00	16,947,387.98	118,872,600.00	69,192,141.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	27,230,000.00	18,586,439.24	53,543,600.00	42,629,362.52
210201	Тэтгэврийн даатгал	19,161,800.00	12,714,919.38	36,409,600.00	29,412,060.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,017,000.00	1,495,872.80	4,283,500.00	3,460,242.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,613,700.00	1,196,698.40	3,426,800.00	2,768,194.08
210204	Ажилгүйдлийн даатгал	403,400.00	274,270.99	856,800.00	624,631.94
210205	Эрүүл мэндийн даатгал	4,034,100.00	2,904,677.67	8,566,900.00	6,364,233.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,059,100.00	42,059,084.22	52,877,800.00	52,631,566.78
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,906,284.22	6,372,000.00	6,233,591.40
210302	Түлш, халаалт	39,059,100.00	39,152,800.00	46,505,800.00	46,397,975.38
2104	Хангамж, бараа материалын зардал	12,926,100.00	12,323,152.80	20,161,200.00	20,136,679.95
210401	Бичиг хэрэг	1,405,000.00	1,404,553.00	2,000,000.00	2,479,880.00
210402	Тээвэр, шатахуун	9,001,100.00	9,000,000.00	10,161,200.00	10,146,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,520,000.00	1,918,599.80	4,000,000.00	3,518,999.95
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	0	0	4,000,000.00	3,991,800.00
2105	Нормативт зардал	240,000.00	240,000.00	1,000,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	240,000.00	240,000.00	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,499,960.00	2,300,000.00	2,300,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,499,960.00	2,300,000.00	2,300,000.00
2107	Томиллолт, зочны зардал	5,579,000.00	4,496,000.00	4,978,000.00	4,960,000.00
210702	Дотоод албан томиллолт	5,579,000.00	4,496,000.00	4,978,000.00	4,960,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	24,997,300.00	23,492,493.99	11,154,000.00	7,888,278.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	23,631,300.00	22,446,097.99	9,500,000.00	6,241,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	720,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,206,600.00	21,822,750.00	31,223,600.00	31,133,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,206,600.00	21,822,750.00	31,223,600.00	31,133,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,026,300.00	15,025,300.00	5,528,000.00	5,492,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,026,300.00	15,025,300.00	5,528,000.00	5,492,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,026,300.00	14,026,300.00	0	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	999,000.00	5,528,000.00	5,492,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,800,000.00	39,761,490.00	293,870,000.00	293,808,005.20
222001	Тоног төхөөрөмж	0	0	15,000,000.00	15,000,000.00
223001	Бусад хөрөнгө	38,800,000.00	39,761,490.00	278,870,000.00	278,808,005.20
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	393,266,300.00	329,655,987.98	895,767,600.00	806,309,399.41
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	354,466,300.00	329,655,987.98	616,897,600.00	806,309,399.41
320001	Орон нутгийн төсвөөс	354,466,300.00	329,655,987.98	616,897,600.00	806,309,399.41
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	38,800,000.00	0	278,870,000.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	38,800,000.00	0	278,870,000.00	0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	45	45	45	45
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22	22	22
620001	Удирдах ажилтан	5	5	5	5
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3	3	3
620004	Гэрээт ажилтан	5	5	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22	22	22	22
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	9	9	9	9
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	4	4	4	4

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	75,033,410.13	355,447,324.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	75,033,410.13	355,447,324.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,409,207.00	336,639,357.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0	24,387,480.81
210101	Үндсэн цалин	0	1,011,723.44
210102	Нэмэгдэл	0	23,375,757.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	3,233,273.29
210201	Тэтгэврийн даатгал	0	2,084,287.79
210202	Тэтгэмжийн даатгал	0	245,210.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	364,312.46
210204	Ажилгүйдлийн даатгал	0	49,042.05
210205	Эрүүл мэндийн даатгал	0	490,420.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,409,207.00	309,018,603.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,409,207.00	309,018,603.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,624,203.13	18,807,967.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,379,600.00	0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,379,600.00	0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,244,603.13	18,807,967.53
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил	18,244,603.13	0
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	0	18,807,967.53
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	75,033,410.13	355,447,324.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,033,410.13	355,447,324.63
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	23,942,693.00	230,746,917.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	51,090,717.13	124,700,407.63
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь сумын Засаг даргатай 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 29 арга хэмжээ баталснаас 26 арга хэмжээ бүрэн хэрэгжиж 90.4 %-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/08 тоот тушаалаар байгууллагын бүтэц, орон тоог төрийн захиргааны 9, төрийн үйлчилгээний 4 албан хаагчтайгаар баталж, үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, төр эдийн засаг нийгмийн бодлогын удирдлага үйл ажиллагааг хангах, оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтийг нэмж тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2013 онд аймгийн хэмжээнд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэж, 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн №06/22 албан тоотоор Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 507,718.8 мянган төгрөгөөр буюу 38,5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	725.0	104,060.8	103,335.8
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	142,299.5	121,358.8	(20,940.6)
Үндсэн хөрөнгө	1,175,523.0	1,599,346.6	423,823.6
Нийт хөрөнгө	1,318,547.5	1,824,766.3	506,218.8
Өр төлбөр	1,025.2	1,573.6	548.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,317,522.3	1,823,192.7	505,670.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,318,547.5	1,824,766.3	506,218.8

Дээрх хүснэгтээс харахад авлагын үлдэгдэл оны эцэст 104,060.8 мянган төгрөг болж, оны эхнээс 103.3356 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Гарден сити ХХК 5,600.0 мянган төгрөг, иргэн Баярмаад 4,334.3 мянган төгрөг, Баялаг фийд 3,750.0 мянган төгрөг, Мал хамгаалах сан 2,561.6 мянган төгрөг, Есөн хэлхээ 87,089.9 мянган төгрөгийн авлага үүссэн нь нөлөөлсөн байна.

Бараа материал дансны хувьд бичиг хэргийн материал 464.2 мянган төгрөг, аж ахуйн материал 4,307.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, түлш шатах тослох материал 5,065.7 мянган төгрөг, биологийн хөрөнгө 18,306.2 мянган төгрөг, бусад хангамжийн материал 1,753.9 мянган төгрөг, барилгын засварын материал 286.5 мянган төгрөг, мал амьтад 253.5 мянган төгрөг, хүнсний материал 46.3 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж, орон сууц 324,265.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 15,901.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 118,024.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 53,881.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 324,265.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 39,591.0 мянган

төгрөгийн машин тоног төхөөрөмж, 350.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 147,133.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 45,594.0 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгө худалдан авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 2 айлын орон сууц 99,564.9 мянган төгрөг, нийтийн бие засах газар эко бохир цооног, ЗДТГ-ын цооног 104,433.4 мянган төгрөг, гэрэлтүүлэг 12,000.0 мянган төгрөг, компьютер /Баг ХАА тасаг/ 6,843.3 мянган төгрөг, ус түгээх автомат ухаалаг худгийн төхөөрөмж 10,000.0 мянган төгрөг 232,841.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Ус-21 төслийн худгийн байшин болон наадмын талбай барилга байгууламжийг сайжруулалтаар 100,400.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

Төсвийн хөрөнгөөр санхүүгийн албанд 15,000.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, цомцог Монгол гэр 20,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь нөлөөлсөн байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал 122,802.6 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,826,266.3 мянган төгрөг болж 507,718.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 589,899.5 мянган төгрөг, нийт зарлагыг 589,899.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 305,868.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2023 оны урсгал зардлын төсвийг 895,767.6 мянган төгрөгөөр баталж, санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 619,897.6 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 278,870.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор тайлант оны батлагдсан төсөв 547,830.3 мянган төгрөгийг 347,937.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 895,767.6 мянган төгрөгөөр тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага гэсэн 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг 616,897.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 278,870.0 мянган төгрөгийг урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 91,4 хувь буюу 823,583.0 мянган төгрөгийг олгож, оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 17,273.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 806,309.4 мянган төгрөг буюу 90,01 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, бараа ажил үйлчилгээний зардлаас 17,273.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	460401.6	393885.8	66,515.8	85.55%
2		80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	60791.9	55094.9	5,697.0	90.63%
3		80106- Баг, хорооны үйл ажиллагааны зардал	39952.5	22903.8	17,048.7	57.33%
4		80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	5528.0	5492.0	36.0	99.35%
5		80918-Бусад	293870.0	293808.0	62.0	99.98%
6		81102- Орон нутгийн нөөц хөрөнгө	5000.0	5000.0	0.0	100.00%
7		82801- Улсын их баяр наадам	5000.0	5000.0	0.0	100.00%
8	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	81701- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	21223.6	21133.0	90.6	99.57%
9		82212- Хур хог хаягдал, орчны бохирдол	4000.0	3991.8	8.2	99.80%
Дүн			895,767.6	806,309.4	89,458.2	90.01%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төрийн албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын зардалд 41,740.7 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын урамшуулалд 683.0 мянган төгрөг, аймгийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт 182,638.2 мянган төгрөг, усны мөнгө 230.0 мянган төгрөг, баяр наадмын зардал 5,000.0 мянган төгрөг, өвс тэжээл борлуулсны орлого 124,700.4 мянган төгрөг нийт 355,447.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс цалинд 27,620.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 309,018.5 мянган төгрөг нийт 336,639.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Зарцуулаагүй үлдэгдэл 18,808.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/ мянган төгрөгөөр /

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлнэ.	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 89.7%	870,544.0	781,184.6
2	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2023.01.01-2023.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хэрэгжүүлнэ.	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр 99.6 %	25,223.6	25,124.8

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага /70106/ хөтөлбөр 89,7 хувиар, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага /71411/ хөтөлбөр 99,6 хувиар хэрэгжсэн нь 2023 оны төсвийн жилд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор хэмнэгдсэн 17,273.6 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу тендер шалгаруулалтын онцгой журмаар 11 тендерийг зарлаж, шинээр наадмын талбай байгуулсан, нийтийн бие засах газар соруулдаг эко нойл хийсэн, төрийн албан хаагчийн 2 айлын орон сууц барьсан, спорт чийрэгжүүлэлтийн талбай байгуулсан, сумын төвд шөнийн туузан гэрлүүд шинээр хийсэн, Зуун мод хотод шинээр байгуулагдсан өв соёлын өргөө цогцолборт өөрийн цомцог гэртэй болсон зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн байна.

Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийгдээгүй байна. Энэ нь цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, ажил үйлчилгээний сонголт бага, өртөг зардал өндөр байгаа тул өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, шууд худалдан авалт хийж гэрээ байгуулан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/45 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны төсвийн төлөвлөгөөний нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага 895,767.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 13,436.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 9,405.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээнээс хэмнэгдсэн 17,273.6 мянган төгрөгийн зардлыг татан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий

орлогын 12, зарлагын 12 мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 22 шийдвэрийг хугацаандаа байршуулж, байршуулбал зохих 159 мэдээллээс, хугацаа болоогүй 2 мэдээлэл, байршуулаагүй 10 мэдээлэл, хугацаандаа байршуулсан 147 мэдээлэл, хуулийн хэрэгжилт 75,0 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ. Энэ нь Шилэн дансны хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлд 10 тендерийн талаар бүрэн мэдээлээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж аудитаар нийт 40,279.8 мянган төгрөгийн зөрчилд 8,629.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 31,650.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс улс төрийн албан хаагчдад илүү олгосон орон нутгийн нэмэгдэл төлүүлэх акт төлөгдөөгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 03/32 тоотоор ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн шийдвэрлэлт	Өмнөх он		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	5	19,785.7	5	19,785.7	100.0
Зөвлөмж	1	16,517.0	1	16,517.0	100.0
Нийт дүн	6	36,302.7	6	36,302.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар 2022 онд хүлээн авч бүртгэсэн тракторын ашиглалт, түрээсийн гэрээний үр дүнгийн байдлыг үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 173,521.5 мянган төгрөгийн алдаа¹ аудитын явцад 173,521.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 17,273.6 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэж, төсвийн татан төвлөрүүлсэн дүнгээр тохируулга хийгээгүй, нэмэлт санхүүжилтийн тайлан нь өмнөх үеийн тоон үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэхүйц байх зарчмыг хангаж бэлтгээгүй алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

2. Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардлын биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардал үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаас 122,247.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

3. Үндсэн хөрөнгийн шинжтэй 5 ханатай гэр, эрээн гэр, 8 ханатай гэр, морины төхөөрөмж зэрэг 34,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “Ангилал”, “Толилуулга”, “Нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

Аудитаар нийт 339,030.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 8,008.2 мянган төгрөг 1 төлбөрийн акт, 97,033.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 233,989.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж бичигдсэн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

1. Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн “Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл, цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай” Б/02 тоот захирамж, Баяндэлгэр сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Цалин шинэчлэн батлах тухай” Б/01 тоот захирамж, Баяндэлгэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Цалин шинэчлэн тогтоох тухай” Б/01 тоот тогтоолоор Төрийн албаны улс төрийн 6 албан тушаалтанд орон нутгийн нэмэгдэлд 8,008.8 мянган төгрөг олгосон зөрчил байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 -д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэж заасны дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

1. Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ төлбөрийн цахим баримтын дүнтэй тулгалт хийхэд е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 74,724.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага өгнө гэж заасны дагуу шийдвэрлэв.

2. Өмнөх оны аудитаар өгөгдсөн ОНХС болон бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр ирсэн ухна, хуц, бух нийт 22,308.7 мянган

төгрөгийн мал амьтдыг малчдад олгосон гэрээг дүгнэсэн баримтыг санхүүгийн баримтад хавсаргаж байх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, гэрээг дүгнэсэн баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-д “Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслүүлэх хугацаа, төлбөр, нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгана” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага өгнө” гэж заасны дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Хөрөнгийн зардлаас шатахуун, сэлбэг хэрэгсэл, тэтгэмж, малын тэжээл, өргөмжлөл, ажлын хөлс зэрэг 46,218.2 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Ангилал”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн төлөвлөлтийг боловсруулахдаа Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 тоот тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдлөг болгож, хөрөнгийн зардлаас урсгал зардалд зарцуулахгүй байх

2. Бусад асуудал

2.1.Илрүүлэлт:

Байгууллагын эзэмшилд байгаа 17 газраас 15 газар бүртгэлтэй байна. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 152.0 мянган төгрөгийн газар, Газрын гэрчилгээний дугаарын дагуу газрын хэмжээс, үнэлгээг тулгаж, данс бүртгэлд аваагүй 1,998.0 мянган төгрөгийн нийт 2,150.0 мянган төгрөгийн газрын бүртгэл зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “иргэдэд өмчлүүлснээс бусад газар”, 72 дугаар зүйлийн 72.4.1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн

5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын эзэмшилд байгаа бүртгэлтэй газрын гэрээг сунгаагүйгээс хүчингүй болсныг гэрээг сунгах, байгууллагын эзэмшилд байх газрын кадастрын зургийг авч, санхүүгийн тайлангийн биет хөрөнгийн дансанд газрын нэршил, газрын хэмжээ, үнэлгээг үндэслэн бүртгэж авах

3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3.1.1.Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд их хэмжээгээр авлага үүсгэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан баримтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Тасалбар болголт”, “Иж бүрэн байх” “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2.Өгсөн зөвлөмж:

Авлага үүссэн тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу тооцоо нийлсэн актыг үндэслэн бүртгэж тайлагнах

3.2.1.Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад зөрүүтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2.Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийн тооллогын бэлтгэл ажлыг байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар бүрэн хангаж, үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрэн бүрдүүлж ажиллах

3.3.1.Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 370,459.6 мянган төгрөгийн өртөгтэй 1104 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай”, 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй

боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хувиарлалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2.Өгсөн зөвлөмж:

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн хүргүүлж, шийдвэрлүүлэх

3.4.1.Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад 86,619.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.4.2.Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийн тооллогын бэлтгэл ажлыг байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар бүрэн хангаж, бараа материалын хөдөлгөөн өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, баримт бичгийг бүрдүүлж, тооллогын комисс ажиллуулах

4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1.Илрүүлэлт:

Шилэн дансны хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлд 10 тендерийн талаар бүрэн мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлд шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг бүрэн оруулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		НББ-ийг буруу хэрэгжүүлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Этайлангийн мөнгөн гүйлгээний тайланд төсвийн гүйцэтгэлийн тохируулга хийгдээгүй байна.	1	17,273.6	1	17,273.6	-	-	1	17,273.6	-	-	-	-
Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардлын биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардал үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаас зөрүүтэй	1	122,247.9	1	122,247.9	-	-	1	122,247.9	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн шинжтэй 5 ханатай гэр, эрэн гэр, 8 ханатай гэр, морины төхөөрөмж зэрэг хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.	1	34,000.0			1	34,000.0	1	34,000.0	-	-	-	-
Дүн	3	173,521.5	2	139,521.5	1	34,000.0	3	139,521.5	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Улс төрийн 6 албан тушаалтанд орон нутгийн нэмэгдэлд олгосон зөрчил байна.	1	8,008.8	1	8,008.8	-	-	-	-	-	-	-	-
Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байна.	1	74,724.3	-	-	1	74,724.3	-	-	-	-	-	-
ОНХС болон бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй ухна, хуц, бухыг гэрээлсэн гэрээний хэрэгжилт гэрээг дүгнэсэн баримтгүй байна.	1	22,308.7	-	-	1	22,308.67	-	-	-	-	-	-
Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад зөрүүтэй байна.	1	86,619.2	-	-	-	-	1	86,619.2	-	-	-	-
Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад зөрүүтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Элэгдлээрээ анхны өртөө нөхсөн мянган төгрөгийн өртөтэй ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Байгууллагын эзэмшилд байгаа 17 газраас 15 газар бүртгэлтэй байна.	1	2,150.0	-	-	-	-	1	2,150.0	-	-	-	-
Санхүүгийн тайланд их хэмжээгээр үүсгэсэн тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан баримтгүй байна.	1	99,001.5	-	-	-	-	1	99,001.5	-	-	-	-
Хөрөнгийн зардлаас шатахуун, сэлбэг хэрэгсэл, тэтгэмж, малын тэжээл, өргөмжлөл, ажлын хөлс зэрэг урсгал зардлыг санхүүжүүлсэн байна.	1	46,218.2	-	-	-	-	1	46,218.2	-	-	-	-
Дүн	7	339,030.8	1	8,008.8	2	97,033.0	6	233,989.0	-	-	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлд 12 тендерийн талаар бүрэн мэдээлээгүй байна.	1	-					1	-
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0	0	0	0	0	1	0